

2013 оны Эрдэнийн Говь арга хэмжээн дээр хэлсэн үг

2014 оны 4 дүгээр сарын 29

Айвен Велла, Оюу Толгой ХХК-ийн Үйлдвэрлэл хариуцсан Дэд захирал

Эрхэм бэлтгэн нийлүүлэгч компаниудын төлөлөгчид, хүндэт зочид оо, Та бүгдийн энэ өдрийн түмэн амгаланг айлтгая.

Манай компанийн үндэсний худалдан авалтын бодлогын хувьд маш их ахиц дэвшил гарсан жил дуусч байна.

Өнгөрсөн онд, бид Монголдоо хийсэн худалдан авалтаа 76 хувиар нэмэгдүүлж чадлаа.

Нийт худалдан авалтад цэвэр Монгол компаниудын эзлэх хувийг 2013 онд бид 40 хувьд хүргэж, энэ жил улмаар 55 хувь болгон нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Өнгөрсөн жил манай үндэсний бэлтгэн нийлүүлэгчдийн тоо 949-д хүрлээ. Эдгээр 949 Монгол компаниудад нийт 35,000 хүн ажиллаж байна.

Энэ тооны ард, олон чиглэлээр Монголоос анх удаа бараа, үйлчилгээ худалдан авсан, улмаар бидний мөрддөг аюулгүй ажиллагаа, чанарын олон улсын стандартуудыг хэрэгжүүлж ирсэн олон сайхан жишээ бий. Түлш, тос, манай ажиллагсдын өдөр бүр иддэг хоол хүнс, гэх мэт олон жишээ дурьдаж болно.

Бид хамтдаа энэ бүх амжилтыг бий болгосонд туйлын баяртай байна.

Хүмүүс заримдаа асуудаг, яагаад бид ийм бодлого хэрэгжүүлдэг вэ?

Энэ нь бидэнд яагаад хамаатай байдаг вэ? Яагаад бид Монголын бэлтгэн нийлүүлэгчдэд давуу эрх олгодог вэ?

Яагаад бид компани бүрийн амжилтын түүхийг хуваалцаж, түүнээс сургамж авах ёстой гэж үздэг вэ?

Яагаад үндэсний бэлтгэн нийлүүлэгчдийн сүлжээг бүрдүүлэх нь манай компанийн хувьд нэн тэргүүний ач холбогдолтой байдаг вэ?

Хариу нь маш хялбар....

Нэгдүгээрт– Монголдоо хангамжийн сүлжээ бүрдүүлэх нь илүү аюулгүй, илүү тогтвортой байдаг.

Бараа, бүтээгдэхүүнийг шууд импортоор авах нь илүү их цаг хугацаа шаарддаг, үүнээс болж ажил саатаж, орлого алдагдах аюул эрдсэл гардаг.

Хоёрдугаарт- энэ нь илүү үр ашигтай. Илүү хямд байдаг.

Бараа, бүтээгдэхүүнийг шууд импортоор авах нь илүү их зардалтай, бас бидэнд нэмэлт ажил учруулж үндсэн үйл ажилагаанаас сатааруулдаг.

Хангамжийн аюулгүй байдал, үр ашиг нь хувь нийлүүлэгчдэд үр шимээ өгч ажилладаг, үйл ажиллагаа жигдэрсэн амжилттай бизнесийн байгууллагын хувьд онц чухал ач холбогдолтой байдаг. Ингэснээр оновчтой, зардал багатай, ашигтай үйлдвэрлэл явуулах боломж бүрдэнэ.

Энэ нь мөн хийх ёстой, зөв бодлого гэдэгт бид огт эргэлзэхгүй байна. Бид Монголын компани мөн. Бид дотоод чадавхиа бүрдүүлэх Монголын Засгийн газрын алсыг харсан бодлогыг дэмжиж ажиллахын тулд үйл ажиллагааны зардлын аль болох их хувийг дотооддоо зарцуулах зорилт тавьж байна. Бид ийм л компани бий болгохын төлөө ажиллаж байна, бидний хамтын ажиллагаа, түншлэл бэхжүүлэхэд энэ бодлого нэн чухал ач холбогдолтой.

Бид хангамж, худалдан авалтын бодлогоор дамжуулан тавьсан зорилтдоо хүрэхгүй бол, бид амжилт олж чадахгүй. Энэ бол бидний бизнесийн нэгэн том суурь багана мөн, бид үүнийг цаашид ч бэхжиж хөгжүүлэх болно.

Та бүхэнд өгөх миний гол мессэж бол:

Бидний ажилладаг салбар нилээд хүнд хэцүү байдаг. Бид бүгд өнөөдөр нилээд хатуу ширүүн орчинд ажиллаж байгааг та бүхэн мэдэж байгаа. Зардлаа барьж ажиллах шаардлага гарч байна, бас ирээдүйн талаар тодорхойгүй байдал үүсээд байна.

Гэхдээ энэ бүх сорилтын ард, асар их боломж байна.

Бид ханган нийлүүлэгчдээс юу шаардаж байдгийг та бүхэн мэдэж байгаа. Та бүхэн энэ сорилтыг цаашид ч даван туулж чадах бол, бид та нартай ирээдүйд ч ажиллах сонирхолтой байх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй.

Хичээн зүтгэж ажиллацгая. Аюулгүй ажиллагааг чанд сахин, мэргэжлийн үр чадвараа харуулж, үр ашигтай ажиллах бол, Оюу Толгойтой хамтран ажиллах, ажиллах хүчээ өргөжүүлэх, амжилтаа улам бататгах асар их боломж та бүхэнд үргэлж гарах болно.

Та бүхэнд дахин талархлаа илэрхийлье.